

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛ



Улаанбаатар хот
2018 он



НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан уулын ар хормой, Туул голын савд 48.5 мянган га нутаг дэвсгэрийг эзэлж оршдог. Тус дүүрэг нь 2017 оны байдлаар 16 хороо, 47.2 мянган өрхийн 169.7 мянган хүн амтай байна.

Хүснэгт 1. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж

Хороо	Нутаг Дэвсгэрийн хэмжээ ¹ (км ²)	Хүн амын нягтрал (1 км ² -д ногдох хүн)
1-р хороо	0.3	34287
2-р хороо	1.4	8657
3-р хороо	4.5	3756
4-р хороо	36.3	299
5-р хороо	1.5	3970
6-р хороо	0.9	7551
7-р хороо	1.1	4554
8-р хороо	45.2	251
9-р хороо	4.2	2181
10-р хороо	32.6	376
11-р хороо	34.2	502
12-р хороо	57.1	104
13-р хороо	125.7	33
14-р хороо	153.1	33
15-р хороо	3.1	7698
16-р хороо	2.3	5614
Дүн	503.5	337

Газрын нэгдмэл сан нь шинэчлэн найруулсан Монгол Улсын газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн 6 санд хуваагдаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн газрын нэгдмэл сан нийт 50352 га байна. Үүнээс: хөдөө аж ахуйн газар 22451.12 га (44.6%), хот тосгон бусад суурин газар 7088.18 га (14.1%), зам шугам сүлжээний газар 2960.3 га (5.9%), ойн сан бүхий газар 2098.0 га (4.2%), усан сан бүхий газар 975.0 га (1.9%), улсын тусгай хэрэгцээний газар 14779.0 га (29.3%)-ийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Газрын нэгдмэл сан¹



Нийт 50351 га газраас иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн нийт 619.1 га, иргэний гэр хорооллын эзэмшилд нийт 1142.7 га, төрийн байгууллагын эзэмшилд нийт 244.0 га, аж ахуйн нэгжийн эзэмшилд 1775.2 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд 55.7 га, хөдөө аж ахуйн эзэмшил, ашиглалтанд нийт 958.5 га, хот тосгон бусад суурин газрын эзэмшил, ашиглалтанд нийт 2878.2 га тус тус байна.

ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ


2017 онд Хан-Уул дүүргийн нийт өрхийн 45.5 хувь нь гэр хороололд, 54.5 хувь нь орон сууцны хороололд оршин сууж байна. Дүүргийн гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо 2008 оноос эхлэн нэмэгдэж, 2011 оны байдлаар нийт өрхийн 58.7 хувь, 2012 онд 57.0 хувь, 2013 онд 56.4 хувь, 2014 онд 51.9 хувь, 2015 онд 50.1 хувь, 2016 онд 48.0 хувь, 2017 онд 45.5 хувь нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 1. Орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрхийн судалгаа

Үзүүлэлт		2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт өрхийн тоо		31517	33982	35349	39189	43280	45200	47202
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	13027	14610	15425	18853	21612	23508	25723
	нийтийн орон сууцны	12751	14326	15064	18473	21035	22912	25092
	тусдаа тохилог орон сууц	275	284	358	380	571	591	626
	орон гэргүй	1	-	3	-	6	5	5
	Гэр хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	18490	19372	19924	20336	21668	21692	21479
	тохилог орон сууцанд	163	175	149	155	377	418	363
	байшинд амьдардаг	12145	12574	12587	12674	11664	11453	11805
	монгол гэрт амьдардаг	6155	6597	7150	7486	9613	9805	9296
	орон гэргүй	27	26	38	21	14	16	15
	Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	41.3	42.9	43.6	48.1	49.9	52.0	54.5
Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	58.7	57.0	56.4	51.9	50.1	48.0	45.5	

Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны барилгууд ихээр нэмэгдэж, 2011 оноос орон сууцны хорооллын өрхийн тоо 15685 өрхөөр нэмэгдсэн хэдий ч нийслэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шүүд шалтгаалж гэр хорооллын өрх, хүн амын тоо буурахгүй байна.

Зураг 1. Дүүргийн өрх, байршлаар




2017 онд орон сууцны хорооллын өрхийн тоо 25723 болж, өнгөрсөн онтой харьцуулахад 2215 өрх (9.4%) өссөн байна. Орон сууцны хороололд амьдардаг 25723 (97.5%) өрхийн 25092 өрх нийтийн зориулалттай орон сууцанд, 626 (2.4%) өрх тусдаа тохилог орон сууцанд амьдарч байна.

Хүснэгт 2. Дүүргийн өрх, байршил, сууцны төрлөөр, 2017 он


Хороо	Нийт өрх	Үүнээс:						
		Орон сууцны хороололд			Гэр хороололд			
		Нийтийн орон сууц	Тусдаа тохилог орон сууц	Орон гэргүй	Тусдаа тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Монгол гэр	Орон гэргүй
Нийт дүн	45200	22912	591	5	418	11453	9805	16
1-р хороо	2312	2308	4	-	-	-	-	-
2-р хороо	2750	2696	9	5	-	-	40	-
3-р хороо	4379	4308	17	-	-	-	54	-
4-р хороо	3224	1218	-	-	11	1050	940	5
5-р хороо	1532	-	-	-	-	1221	311	-
6-р хороо	1943	-	-	-	62	1218	663	-
7-р хороо	1412	-	-	-	16	867	529	-
8-р хороо	3351	2	-	-	2	1720	1627	-
9-р хороо	2526	-	-	-	-	1407	1118	1
10-р хороо	2626	1208	31	-	2	789	596	-
11-р хороо	4144	3022	396	-	209	185	332	-
12-р хороо	1792	231	-	-	24	1023	512	2
13-р хороо	1403	108	-	-	57	405	830	3
14-р хороо	1644	-	-	-	12	517	1115	-
15-р хороо	6670	6527	134	-	-	3	6	-
16-р хороо	3492	1284	-	-	23	1048	1132	5

Зураг 2. Дүүргийн өрх, сууцны төрлөөр



Гэр хороололд суурьшсан өрхийн тоо 2011 оноос 2989 өрхөөр нэмэгдэж, 2017 оны эцэст 21479 өрх болов. 2016 онтой харьцуулахад 213 (1.0%) өрх хасагдсан байна. Гэр хороололд суурьшсан 21479 (43.3%) өрхийн 9296 нь монгол гэрт, 11805 (45.0%) нь байшинд, 363 (1.7%) нь тохилог орон сууцанд, 15 (0.1%) өрх орон гэргүй амьдарч байна.

Зураг 3. Орон гэргүй өрх, оршин суугаа байршлаар



2017 онд нийт өрхөөс 20 (0.09%) өрхийн 31 хүн орон гэргүйн улмаас үрц овоохой, шатны хонгил зэрэг хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч байна. Үүнээс орон гэргүй 15 өрхийн 26 хүн гэр хороололд байна.